MONT
WHITEPAPER

АГУУЛГА

ОРШИЛ 1
ТАНИЛЦУУЛГА 4
ШИЙДЭХ АСУУДАЛ 3
ҮНЭ ЦЭН 4
ХЭРЭГЛЭЭ 5
БАТАЛГАА 6
MONT-ЫН ХЭМЖЭЭ 7
MONT ҮҮСГЭХ БОЛОН УСТГАХ ПРОЦЕСС 8
АЮУЛГҮЙ БАЙДАЛ 9
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН 10
БИДНИЙ ТУХАЙ 11

МЭДЭГДЭЛ

Энэхүү Уайтпэйпер буюу Техник, Технологи, Эдийн Засгийн Үндэслэл (ТТЭЗҮ) нь Монгол Тетер буюу MONT-д холбогдох бүхий л мэдээллийг тусгаагүй болно.

Технологи болон хууль эрх зүйн шаардлагаар энэхүү ТТЭЗҮ-д өөрчлөлт орж болно.

Дараах мэдэгдлийг анхааралтай уншина уу.

Энэхүү мэдэгдэл нь ТТЭЗҮ-г уншиж буй бүх хүмүүст хамаарна. ТТЭЗҮ-г зөвхөн MONT-ыг нэвтрүүлэхтэй холбогдуулан бэлтгэсэн бөгөөд зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор олон нийтэд нээлттэй болгож байгаа танилцуулга болно.

Энэхүү баримт бичиг болон вебсайтад нийтэлсэн, түгээсэн болон бусад байдлаар ашиглах боломжтой бүх мэдээлэл, материалууд нь мэдээлэл өгөх зорилгоор, зөвхөн таны хувийн хэрэгцээнд зориулагдсан болно. Энэ баримт бичгийн агуулгыг ямар ч тохиолдолд санхүүгийн зөвлөгөө гэж үзэж болохгүй бөгөөд та өөрийн гаргасан санхүүгийн шийдвэрт өөрөө хариуцлага хүлээнэ гэдгийг ямагт санана уу.

Энэхүү танилцуулга нь аливаа хэлбэрээр MONT-ыг худалдан авахыг санал болгох, уриалах, гэрээ хийхэд нөлөөлөх зорилгыг агуулаагүй бөгөөд тус танилцуулгатай уншиж танилцсанаар талууд хооронд ямарваа эрх зүйн харилцаа үүсэхгүй болно.

1. ОРШИЛ

1.1 ВИРТУАЛ ХӨРӨНГӨ

Даяарчлалын давалгаа дэлхий дахиныг нөмөрсөн мэдээллийн шинэ эрин үед виртуал хөрөнгө хэмээх алтнаас ч үнэтэй арилжаалагддаг шинэ үнэт хөрөнгө үүсэж хамгийн халуун сэдвүүдийн нэг болжээ. Энэхүү алтнаас үнэтэй гэгдэх гарт баригдахгүй, зөвхөн нүдэнд тоон хэлбэрээр харагдах хий хоосон мэт зүйл үнэд хүрсэн хамгийн гол хүчин зүйл бол түүний цаана орших буй технологи юм. Өөрөөр хэлбэл виртуал хөрөнгө нь алт шиг газраас ухалгүй технологиор бүтээсэн үнэт зүйл билээ. Алт, мөнгө гэх мэт бусад үнэт зүйлсийн үнэ цэнийг урт хугацаанд хадгалах боломжтой, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, хялбархан хуулбарлах боломжгүй зэрэг шинж чанар нь тодорхойлж, улмаар зах зээлд зохих эрэлтийг бий болгосон байдаг. Энэхүү зарчмын дагуу авч үзвэл виртуал хөрөнгө нь дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдөж, тодорхой хэмжээний эргэлтэнд орон, удаан хугацаанд хадгалах боломжтой, хуулбарлах боломжгүй үнэт зүйл болж чаджээ.

1.2 СТЕЙБЛКОЙН

Стэйблкойн нь виртуал хөрөнгийн зах зээл болон үнийн тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ аливаа хөрөнгийн үнийг зөвөөр үнэлэх хамгийн үр дүнтэй бөгөөд найдвартай арилжааны арга хэрэгсэл юм.

Хүмүүсийн дунд хүлээн зөвшөөрөгдөж, зах зээл дээрх эрэлт нь ихсэх тутамд тухайн зүйлийн үнэ нь нэмэгдэж байдаг. Уг зарчмын дагуу хамгийн анхны виртуал хөрөнгө болох Биткойн (Англи нэршил "Bitcoin")-ын үнэ тасралтгүй өсөж анхны үнэ болох 0.08 доллараас 64,863 ам.доллар болтлоо өсөлтийг үзүүлжээ. Үнэ өссөн бол буцаад бууж хэлбэлзэж байдаг гэдгийг бид олон жишээнээс харж байсан. Зах зээлийн энэхүү зарчим нь шинээр бий болсон үнэт зүйл дээр хамгийн ихээр ажиглагддаг билээ. Иймдээ ч хэдхэн жилийн түүхтэй Биткойн болон бусад түгээмэл виртуал хөрөнгийн үнэ нь байнга хүчтэй хэлбэлзэж, тухайн хөрөнгийн эзэмшигчдэд ашиг эсхүл алдагдал хүлээлгэдэг. Ийнхүү виртуал хөрөнгөөс бий болдог ашиг болон алдагдлыг шууд зохицуулах боломж байхгүй ч түүнтэй харьцах тогтсон үнэтэй үнэт зүйл болох стэйблкойн (англи нэршил "Stablecoin") гэх ойлголт олон улсад бий болж, виртуал хөрөнгийн түүхэнд шинэ хуудас нээсэн билээ. Стэйблкойн нь биткойнтой адил блокчэйн технологи дээр суурилан бий болсон виртуал хөрөнгө боловч түүнээс ялгарах гол шинж нь түүний өөр хөрөнгөтэй уяж аргамжсан байдал юм. Долларт суурилсан USDC, USDT гэх мэт стэйблкойнууд түгээмэл хэрэглэгдэж, USDT-ийн нэг өдөрт арилжаалагдах хэмжээ 67 тэрбум ам.доллартхүрч байна.

---

[1] Биткойн нь хамгийн анхны виртуал хөрөнгө бөгөөд дижитал үнэ цэнийн илэрхийлэл.

2021 оны 10 сард Фэйсбүүк компаниас Novi хэмээх крипто хөрөнгийн хэтэвч гаргаснаа зарласан. Тус хэтэвч хэрэглэгчид өөрийн долларыг шууд "Pax Dollar" (USDP) хэмээх стэйблкойн болгон хувиргах, шилжүүлэг хийх, улмаар хэрэглэгчийн хаана амьдарч байгаагаас шалтгаалан, дотоодын валют руу хувирган бэлэн мөнгө татаж авах боломжтой болсон юм. USDP нь "Paxos Trust" компаниас гаргасан ам.доллартой дүйцэх үнэ цэнтэй стэйблкойн юм. Стэйблкойн зохицуулалтгүй хэдий ч хэрэглээнд өргөнөөр нэвтэрч буй байдал нь Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (Цаашид "FATF" гэх) болон бусад бодлого, зохицуулалтын байгууллагуудын анхаарлыг татсаар байгаа. Энэ хүрээнд FATF нь стэйблкойны давуу талыг хүлээн зөвшөөрсөн хэдий ч хууль бус мөнгөний урсгалд хяналт тавихад хангалтгүй гэж үзэж байгаагаа дурдаж байжээ. Үүний шийдэл нь Төв банкны зохицуулалттай дижитал валют буюу CBDC байх боломжтой гэдгийг стэйблкойны хэрэглээг зохицуулах зөвлөмждөө тусгаж байжээ.

1.3 ТӨВ БАНКНЫ ЗОХИЦУУЛАЛТТАЙ ДИЖИТАЛ ВАЛЮТ (CBDC)

Стэйблкойны өсөлт болон мөнгөний цахим хэлбэрийн хэрэглээг анзаарч, дэлхий даяарх төв банкууд үндэсний мөнгөн тэмдэгтээ дижитал хэлбэрээр гаргахаар туршиж байна. Дижитал валютын судалгаа, туршилтын амжилтаараа БНХАУ-ын төв банк манлайлж байгаа бөгөөд Шинжэнь, Шанхай зэрэг хотуудад и-юанийн хөтөлбөрөө хэрэгжүүлээд байна.

Тиймдээ ч Хятадын засгийн газар и-юанийг хэээз өргөн хүрээнд нэвтрүүлэх бол гэдэг асуулт шинжээчдийн анхаарлыг ихэд татах боллоо. Төв банк өөрийн койныг гаргаж, дижитал валют нийлүүлж байгаа нь зохицуулалт болон дэд бүтцийн хувьд томоохон давуу талуудыг олгох учиртай. Зохицуулалтын хувьд, татварын бүрэн төлөлт болон FATF зэрэг олон улсын байгууллагын зөвлөмжийг дагахад энэ нь илүү дөхөм арга зам болно. Дэд бүтцийн хувьд, цаасан мөнгө үйлдвэрлэх, тээвэрлэх, хамгаалах зэрэг зардлыг хэмнэх давуу талтай.

1.4 ВИРТУАЛ ХӨРӨНГӨ БОЛОН ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ШИНЭЧИЛСЭН УДИРДАМЖ

Виртуал хөрөнгийн салбарын хөгжил асар хурдацтай явагдаж, технологийн хувьд байнгын хувьсан өөрчлөгдөж байгаа нь төр болон хувийн хэвшил хоорондын харилцаа холбоо, хяналтыг сайжруулах шаардлагатай болж байна. 2020 оны 6 сард FATF-ын Виртуал хөрөнгө болон Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн шинэчилсэн стандартын тойм нь FATF-ын шинэчилсэн стандартын хэрэглээг тогтоох зорилгоор анхаарал шаардагдаж байгаа салбаруудыг тодорхойлсон бөгөөд FATF 2019 онд гаргасан удирдамжаа дахин хянаж, шинэчлэхээ зарласан юм.

---

[2] Financial Action Task Force (FATF) нь дэлхийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх байгууллага юм

2021 оны 3 ба 4-р сард зохион байгуулагдсан олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнд FATF-аас Виртуал хөрөнгө болон Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрсдэлд суурилсан хандлагын 2021 оны удирдамжийг эцэслэн боловсруулж, FATF-ын зөвлөмжүүддээ эдгээр хөрөнгө болон үйлчилгээ үзүүлэгч нарт хэрхэн хандахыг тайлбарлаж өгчээ. Тэр дотроо энэхүү зөвлөмжид Виртуал хөрөнгө болон Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тодорхойлолт болон G20-ын тайлангуудад стейблкойнд FATF-ын стандартуудыг хэрхэн нэвтрүүлэх талаар тодорхойлж өгсөн болно. Мөн хэрэглэгчээс хэрэглэгчид (P2P) гүйлгээний эрсдэлийг тодорхойлж түүнийг бууруулах арга хэрэгслийн талаар дурдсан байна. Түүнчлэн энэхүү зөвлөмж нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн лиценз, бүртгэлийн талаар дурдсан бөгөөд "travel rule" гэж нэрлэгддэг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэдээлэл солилцох болон хамтын ажиллагааны зарчмыг багтаажээ. Энэхүү шинэчлэгдсэн зөвлөмж нь FATF-ын одоогийн стандартыг хэрэгжүүлж байгаа улс орон болон хувийн хэвшлийн хэрэгцээнд зориулагдсан юм. Үүний хүрээнд FATF Виртуал хөрөнгө болон Виртуал хөрөнгийн үйлчилгээний салбарыг илүү их анхаарч, хяналт тавьж ажиллаж байна. Стейблкойн, хэрэглэгчээс хэрэглэгчид (P2P), NFT, Төвлөрсөн бус санхүүгийн тогтолцоо (DeFi) зэрэг нь дээрх зөвлөмжид хамаарна.

1.5 НӨЛӨӨЛӨЛ

Стэйблкойн бий болсноор виртуал хөрөнгө сонирхогч, арилжаачид болон хөрөнгө оруулагчдын найдвартай сонголт байж тэдгээрийн итгэлийг даасан түгээмэл ашиглагддаг тогтвортой виртуал хөрөнгийн нэг хэлбэр болж чадсан байна. Стэйблкойны тусламжтайгаар түүнийг баталгаажуулж буй валютын нөөц арилжааны банканд байршиж эдийн засгийн эргэлтэд орно. Цаашилбал, бүртгэлийн дэвшилтэт систем блокчэйнд үндэслэсэн стэйблкойны тусламжтайгаар дэлхийн өнцөг булан бүрд, интернэт орон зайд хүмүүс хормын дотор аливаа гуравдагч этгээдийн оролцоогүйгээр шилжүүлэг хийдэг болсон нь хүмүүсийн амьдралыг хялбарчлах бас нэгэн гол хүчин зүйл болжээ. Виртуал хөрөнгийн давуу талууд нь:

(i) оролцогч талуудын тэгш эрх хангагдсан;
(ii) аливаа этгээдээс хамааралгүй;
(iii) орон зайн хязгааргүй;
(iv) цаг хугацааны хоцрогдолгүй;
(v) тогтвортой системтэй;
(vi) аюулгүй;
(vii) аргамжсан хөрөнгийн үнэ цэн, хэлбэлзлийг дагадаг.

Виртуал хөрөнгийн давуу талууд

1
Оролцогч талуудын тэгш эрх хангагдсан
3
Орон зайн хязгааргүй
5
Тогтвортой системтэй
2
Аливаа этгээдээс хамааралгүй
4
Цаг хугацааны хоцрогдолгүй

Энэхүү давуу талуудыг агуулсан Монголын анхны стэйблкойн болох Монгол Тетер (цаашид "MONT" гэх)-ыг Монгол Дифай компаниас боловсруулан хөгжүүлж, Монгол төгрөгтэй аргамжсан стэйблкойныг зах зээл дээр нэвтрүүлснийг ийнхүү мэдэгдэж байна.



2. ТАНИЛЦУУЛГА

2.1 ОНЦЛОГ ШИНЖ

Монгол Улсын Төв банкны тухай хуулиар Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгө тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршдог. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхдээ үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийг гүйлгээнд гаргах, нийлүүлэлтийг хянах, төлбөр тооцоог Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн төгрөгөөр гүйцэтгэх, мөнгөний бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх зэргээр Монголбанкны үйл ажиллагааны чиглэлийг зохицуулсан байдаг. MONT нь виртуал хөрөнгийн арилжаанд оролцогчдын аюулгүй байдал, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын найдвартай, түргэн шуурхай, үр ашигт баталгаажуулах зорилготой бөгөөд төрөөс баримтлах мөнгөний бодлого, Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлж үйл ажиллагаа явуулах болно. Үүнийг эргэлтэнд гаргаж буй MONT-ын тоо, санхүүгийн хөрөнгө хэлбэрээр эзэмшиж буй төгрөгтэй тэнцэх байдлаар хангадаг олон улсын жишгийг дагаж баталгаажуулна.

MONT нь Монгол төгрөгийн ханштай аргамжсан байх буюу нэгийн эсрэг нэг харьцаа (1:1)-тай, санхүүгийн хөрөнгө хэлбэрээр эзэмшиж буй төгрөгөөр баталгаажсан стэйблкойн юм. Тодруулбал, зах зээл дээр гарсан 1 MONT бүрийн цаана санхүүгийн хөрөнгөөр 1 төгрөг ямагт байна гэсэн үг юм.



MONT нь дараах шинжийг агуулна. Үүнд:
- Тэгш эрхтэй талуудын хооронд буюу хэрэглэгчээс хэрэглэгчид (peer to peer) зарчимд үндэслэсэн;
- Аливаа гуравдагч этгээдээс хамааралгүй;
- Ямар ч цаг хугацааны хоцрогдолгүй;
- Орон зайн хязгааргүй;
- BEP20 болон ERC20 стандартын блокчэйн дээр боловсруулагдсан виртуал хөрөнгө юм.

MONT нь виртуал хөрөнгө болон бусад валют руу түргэн шуурхай, чөлөөтэй хөрвөж виртуал хөрөнгийн арилжааг хялбарчлах боломжийг нээнэ.

3. ШИЙДЭХ АСУУДАЛ

MONT нь дараах нийтлэг асуудлыг шийдэх зорилготой юм. Үүнд:

Данс цэнэглэлт

Виртуал хөрөнгийн арилжаанд орохдоо харилцагч нь заавал тухайн арилжааны платформын дансанд мөнгө шилжүүлэн шилжүүлсэн мөнгийг тухайн платформын ажилтан батлахыг хүлээдэг байсан бол MONT-оор дансаа хэдхэн хормын дотор шууд цэнэглэх боломжтой болно.

Ил тод байдал

Харилцагч өөрийн MONT-ын дансны үлдэгдэл, зарлага, орлогын түүх зэрэг мэдээллийг хүссэн үедээ бусад этгээдэд мэдэгдэхгүйгээр харах боломжтой болно.

Шимтгэл

Хил хязгаарт баригдахгүйгээр блокчэйн сүлжээн дээр шилжүүлэг гүйцэтгэх нь уламжлалт шилжүүлгийн системээс илүү зардал багатай болон хурдан шуурхай байх боломжийг бүрдүүлнэ.

Хараат байдал

Харилцагч MONT-ыг ашиглаж хийх аливаа гадаад болон дотоод шилжүүлгийг ажлын цагийн хязгаарт баригдах шаардлагагүйгээр хүссэн цагтаа хийж болно.

Ханшийн хэлбэлзэл

MONT нь Монгол төгрөгт аргамжсан стэйблкойн учир крипто зах зээлийн савалгаанаас ангид юм. Энэхүү үнийн харьцангуй тогтвортой байдал нь крипто арилжаа хийх эрсдэлийг бууруулах болно.

Хурд

Гадаад гүйвүүлга болон дотоодын өндөр дүнтэй шилжүүлэг хийхэд цаг хугацаа алддаг байсныг халж, MONT-ыг хормын дотор блокчэйн сүлжээгээр шилжүүлэх боломжтой болно.

4. ҮНЭ ЦЭН

MONT нь Олон улсад түгээмэл ашиглагддаг токенжуулсан ам.доллар болох USDT болон USDC-тай адил зарчмаар ажиллах бөгөөд эдгээр виртуал хөрөнгийн хамгийн түгээмэл шинж болох аргамжсан хөрөнгийн үнэ цэнийг хадгалдаг чанарыг агуулсан болно.

Цаашилбал, виртуал хөрөнгийн арилжааны платформ дээр арилжаалагдаж байгаагаас бусад тохиолдолд MONT нь энэхүү ТТЭЗҮийн 2-р хэсэгт дурдсанчлан Монгол төгрөгтэй тэнцүү ханштай байх бөгөөд санхүүгийн хөрөнгө хэлбэрээр эзэмшиж буй нөөцийн хэмжээгээр нийт нийлүүлэлт нь тодорхойлогдоно.

Дээр дурдсанчлан 1,000 MONT нь 1,000 төгрөгтэй тэнцүү байх бөгөөд 1 тэрбум төгрөгийн санхүүгийн хөрөнгө байршуулсан тохиолдолд зах зээл дээр нийт 1 тэрбум MONT эргэлтэд орох болно. Ийнхүү MONT-г санхүүгийн хөрөнгө хэлбэрээр баталгаажуулж буй гол зорилго нь түүний зах зээл дээр нийлүүлэлт болон үнэ цэнийг тогтвортой байлгах зорилготой билээ.

Энэхүү үнийн тогтвортой байдал нь MONT-г хамгийн түгээмэл виртуал хөрөнгө болох Биткойн (Англи нэршил "Bitcoin"), Этереум/Этер (Англи нэршил "Ethereum/Ether") зэрэг тогтсон үнэ байдаггүй, зөвхөн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээс хамааран үнэ нь хэлбэлзэж байдаг бусад виртуал хөрөнгөөс ялгаатай зарчмаар зах зээл дээр эргэлтэд орох нөхцөлийг бүрдүүлэх юм. Ам.долларт суурилсан USDC, USDT гэх мэт стэйблкойнууд маш түгээмэл хэрэглэгдэж, USDT-н нэг өдөрт арилжаалагдах хэмжээ биткойн, этереумийн нийлбэр арилжааны хэмжээнээс илүү болжээ.

5. ХЭРЭГЛЭЭ

5.1 ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН АРИЛЖАА

MONT нь Монгол дахь крипто арилжааны зах зээлд шинэ хувьслыг авчирч, Монголын сая гаруй виртуал хөрөнгө эзэмшигчдийн арилжаа хийх зардал болон цаг хугацааг нь хэмнэх гол хэрэгслүүдийн нэг болох боломжтой юм.

Цаашилбал, MONT нь түгээмэл ашиглагддаг блокчэйн болох Этереум, Солана (Англи нэршил "Solana") зэрэг блокчэйнд шилжин, бүртгэгдэж арилжаанд ашиглагдсанаар эдгээр блокчэйн дээрх виртуал хөрөнгө рүү чөлөөтэй хөрвөнө.

Тодруулбал, MONT-ыг бусад виртуал хөрөнгөтэй арилжих боломж бүрэн нээгдэх бөгөөд тухайн арилжааны платформын үүсгэсэн арилжааны хослолын дагуу чөлөөтэй арилжиж, хөрвүүлэг (Англи нэршил "Swapping") хийж болно. MONT эзэмшигч нь өөрийн хүссэн үедээ MONT-оо өөрийн сонгосон виртуал хөрөнгө рүү хөрвүүлэн бусад блокчэйн дээр хүлээн авах боломжтой болно.

6. БАТАЛГАА

6.1 НӨӨЦИЙН БАТАЛГАА

MONT-ын зах зээл дээрх нийт хэмжээг блокчэйн бүртгэлийн систем дээр харах боломжтой байх бөгөөд тогтсон хугацаанд итгэмжлэгдсэн хөндлөнгийн аудитаар зохих шалгалтыг хийлгэж олон нийтэд мэдээлнэ.

6.2 НУУЦЛАЛЫН БАТАЛГАА

MONT-д холбогдох нууц мэдээлэл болох
1. эзэмшигчийн хувийн мэдээлэл;
2. MONT-ын хэмжээ;
3. хүлээн авагч;
4. шилжүүлгийн хэмжээ;
5. бусад Монгол Улсын хуулийн дагуу хамгаалагдах нууц мэдээлэл нь дараах байдлаар хамгаалагдах болно. Үүнд:
- Блокчэйны нийтлэг нууцад хамгаалах горим;
- Үүсгэн байгуулагчдын дотоод журам;
- Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд тус тус хамгаалагдах болно.

7. MONT-ЫН ХЭМЖЭЭ

MONT-ын хэмжээ зах зээл дээрх эрэлтээр тодорхойлогдоно.



Тодруулбал, MONT-ын анхдагч зах зээлийн арилжаа Монгол Улс дахь нэр бүхий виртуал хөрөнгийн арилжааны платформ болох "Digital Assets Exchange" (DAX.mn), "Digital Exchange Mongolia" (Trade.mn)-үүд дээр хийгдсэн бөгөөд MONT-г анхдагч зах зээлийн арилжаагаар дамжуулан хэрэглэгчдэд санал болгосон.

2021 оныг дуустал бусад биржүүд дээр шат дараатай нэвтрүүлнэ.

8. MONT ҮҮСГЭХ БОЛОН УСТГАХ ПРОЦЕС

8.1 ОЛОН ТАЛТ БАТАЛГААЖУУЛАЛТ

MONT-ыг шинээр бий болгох болон устгах процесс нь олон талт баталгаажуулалт (Англи нэршил "Multi signature") буюу гурав ба түүнээс дээш талын зөвшөөрлийн үндсэн дээр хийгдэхээр MONT-ын ухаалаг гэрээнд тусгагдсан болно. Энэхүү "multisig" ухаалаг гэрээ нь "Gnosis Safe" болон "Openzeppelin Defender" систем дээр суурилан ажиллана. "Openzeppelin Defender" нь дэлхийн шилдэг төвлөрсөн бус санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг dYdX болон Aave протоколын аюулгүй байдлыг хангахад ашиглагддаг шилдэг систем юм.

8.2 КОЙН ҮҮСГЭХ БОЛОН УСТГАХ ПРОЦЕСС

MONT зөвхөн "Монгол Дифай" XXK компани үүсгэх болон устгах эрхтэй байна. Харилцагч нь хоёрдогч зах зээлийн арилжаанд оролцохдоо MONT худалдаж авах хүсэлт илгээн, өөрийн дижитал хэтэвчинд төгрөг байршуулснаар MONT худалдаж авах боломж үүснэ.



1. Виртуал хөрөнгийн бирж "Монгол Дифай" XXK компанийн дансанд төгрөг шилжүүлнэ.
2. "Монгол Дифай" XXK компани шинэ MONT үүсгэн, виртуал хөрөнгийн биржийн блокчэйн хаягт байршуулна. MONT эргэлтэд орно.
3. Виртуал хөрөнгийн бирж дээр койн арилжаалагдана. Хэрэглэгчид MONT эзэмшинэ.
4. Хэрэглэгч MONT-г өөрт зохих зорилгоор хэрэглэнэ.
5. Виртуал хөрөнгийн бирж MONT-г төгрөг болгон хөрвүүлэх зорилгоор хэрэглэгчдээс худалдаж авна.
6. Виртуал хөрөнгийн бирж MONT-г төгрөг болгон хөрвүүлэх хүсэлт илгээнэ. MONT-г "Монгол Дифай" XXK-н блокчэйн хаягт байршуулна.
7. "Монгол Дифай" XXK илгээсэн MONT-г зах зээлээс татан авч, тэнцэх хэмжээний төгрөгийг биржийн данс руу илгээнэ.

9. АЮУЛГҮЙ БАЙДАЛ

9.1 ТЕХНОЛОГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Бид виртуал хөрөнгийн аюулгүй байдлыг хангах зорилготойгоор
1. хар жагсаалтын функц;
2. цагаан жагсаалтын функц;
3. түр зогсоох зэрэг функцийг MONT-ын ухаалаг гэрээнд тусган MONT эзэмшигчдийн аюулгүй байдлыг хангаж байгаа болно

Мөн түүнчлэн MONT-ын бүртгэгдэж, шилжүүлэгдэж, ашиглагдах блокчэйн болох Этереум, Солана, Байнанс Смарт Чэйн зэрэг нь өөрсдийн аюулгүй байдлыг өндөр зэрэгт хангасан байдаг тул MONT аливаа хакерын болон бусад халдлагаас бүрэн хамгаалагдсан гэж үзэх үндэслэлтэй.

Цаашилбал, блокчэйн нь зөвшилцлийн механизмаар баталгаажуулан хийгддэг тул MONT-ын гүйлгээнд ямар нэгэн гадны нөлөө үзүүлэх боломжгүй тул MONT эзэмшигчийн хийсэн гүйлгээнд гуравдагч этгээд аливаа өөрчлөлтийг оруулах боломжгүй.

Виртуал хөрөнгийн ухаалаг гэрээний аюулгүй байдал болон бусад шаардлагатай хүчин зүйлсэд аудит хийдэг олон улсын байгууллага болох Сертик (Англи нэр "Certik")-ээр MONT-д аудит хийлгэж аюулгүй байдлыг нь хангаж MONT-д холбогдох аюулгүй гэрчилгээг Сертикээс авснаар MONT нь олон улсын шаардлагатай стандартыг бүрэн хангасан болно.

9.2 НӨӨЦИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

MONT-ын нөөцийг бид Монгол Улсад тогтвортой үйл ажиллагаа явуулж буй харилцагчийн итгэл даасан Монголбанкнаас тодорхойлсон системийн арилжааны банкуудад болон санхүүгийн хөрөнгө хэлбэрээр биржүүдийн дансуудад хадгалах бөгөөд тухайн банк, биржийн аюулгүй байдлыг хангаж хэрэгжүүлж буй систем, зохицуулах байгууллагын хараа хяналт болон тухайн банк, биржийн засаглалын байдал, өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон активын чанар нь MONT-ын нөөцийг хамгаалах хүчин зүйл болно.

10. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

10.1 МОНГОЛ УЛС ДАХЬ ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Виртуал хөрөнгө буюу криптовалют нь Монгол Улсын хувьд харьцангуй шинэ ойлголт бөгөөд сүүлийн хэдэн жил эрчимтэй хөгжиж, энэ талаар сонирхож буй хүмүүсийн тоо эрс нэмэгдэж байгаа тул Монгол Улсын хувьд энэхүү салбарыг зайлшгүй зохицуулах шаардлагатай болсон.

Энэхүү шаардлага болон санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага буюу FATF-аас Монгол Улсад өгсөн үүрэг даалгаврын дагуу "Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль"-ийн төслийг Монгол Улсын их хурал хэлэлцэж, баталсан.

Энэхүү виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн дагуу Монгол Улсад "виртуал хөрөнгө" гэх ойлголт албан ёсоор бий болсон бөгөөд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид болох
1. виртуал хөрөнгийн арилжааны платформ ажиллуулагч,
2. виртуал хөрөнгө шинээр гаргагч болон
3. бусад холбогдох этгээд нь зохих зохицуулалтын дагуу үйл ажиллагаа явуулдаг болно.

Цаашилбал, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн гол зорилго нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд зохих хяналт тавьж, эрх, үүргүүдийг нь тодорхойлох замаар виртуал хөрөнгө эзэмшигч, арилжаанд оролцогч болон бусад холбогдох этгээдүүдийн эрх ашгийг хамгаалж байгаа болно.

Ийнхүү Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг баталж байгаа нь MONT худалдан авагчдын эрхийг хамгаалах гол хэрэглүүрүүрдийн нэг болно гэдэгт бид итгэл төгс байна. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу арилжааны банкинд хадгалсан мөнгөн хөрөнгийн хэмжээ, MONT-ыг үүсгэх, устгах процесс болон түүнтэй холбогдох бусад үйл ажиллагаанд итгэмжлэгдсэн аудитын байгууллагаар тодорхой хугацааны турш тогтмол аудит хийлгүүлэн Монгол улсын хууль тогтоомжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах болно.

10.2 МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ

MONT-ын үүсгэн байгуулагч, шинээр байгуулсан компани болон компанийн удирдах албан тушаалтнууд нь Монгол Улсын болон олон улсын эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах бөгөөд тэдгээрээс ирүүлсэн хүсэлт, тавьсан аливаа шаардлага болон үүрэг даалгаврыг биелүүлэн MONT эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж ажиллана.

Цаашилбал, "Монгол Дифай" XXK компанийн зүгээс MONT арилжаалагдаж буй виртуал хөрөнгийн биржид шаардлага тавьж тэдгээрийн Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, үй олноор зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль болон FATF-ын 10 сарын 28-нд стэйблкойны талаар гаргах зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж буй арга хэмжээтэй нь танилцаж бүрэн хүлээн аван, MONT худалдан авч буй харилцагчид холбогдох харилцагчийг таньж мэдэх (Англи хэлээр "Know Your Customer") зэрэг чиг үүргийг хамтран ажиллах гэрээнд тусгаж ажиллана.

Мөн түүнчлэн, харилцагч нь MONT-ын арилжааны банк дахь дансанд орлого хийхэд болон MONT-г төгрөг болгон зарлага гаргахад тухайн харилцагчийг таньж мэдэх ажиллагааг тухайн арилжааны банк Монгол Улсын холбогдох хуульд нийцүүлэн ажилладаг болно.

11. БИДНИЙ ТУХАЙ

11.1 ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИД

MONT стэйблкойныг "Монгол Дифай" XXK үүсгэж, хариуцах болно. Мөн, стэйблкойны хяналт, хөгжүүлэлт, ирээдүйн төлөвлөгөөнд дараах байгууллагууд зөвлөхөөр ажиллаж байна. Үүнд:
- "Ард Санхүүгийн Нэгдэл" XK
- "ГрэйпСити Монгол" XXK
- "Ард Экс" XXK
- "Дижитал Эксчэйнж Монголиа" XXK
- "Дайверс Солюшнс" XXK
- "Тэнгэрлиг Медиа Групп" XK

Салбартаа тэргүүлэх эдгээр компаниуд нь MONT төслийн бүрэлдэхүүнд багтан, "Монгол Дифай" XXK-д зөвлөж ажиллаж байгаа нь MONT эзэмшигчдийн өмнө гаргаж буй хамгийн том баталгаа болно гэдэгт бид итгэж байна.

11.2 ЗАСАГЛАЛ

Үүсгэн байгуулагчид нь хамтран компани байгуулан MONT-д холбогдох ажил үүргийг гүйцэтгэж, бүрэн хариуцан ажиллана. Үүсгэн байгуулагчдын хөрөнгө оруулалттай "Монгол Дифай" XXK нь 9 (есөн) хүний гишүүнтэй Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)- ийг байгуулан Компанийн тухай хууль, дүрэм журмын хүрээнд эрх олгогдсон ажлуудыг удирдан ажиллана.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц:
1. "Ард Венчюрс" XXK
2. "ГрэйпСити Монгол" XXK
3. "Ард Экс" XXK
4. "Тэнгэрлиг Медиа Групп" X
5. "Эй Ай Дайверс Солюшнс" XX
6. "Дижитал Эксчэйнж Монголиа" XX
7. Ч. Ганхуяг (Гүйцэтгэх захирал, "Ард Санхүүгийн Нэгдэл" XK)
8. Ч. Ганзориг (Гүйцэтгэх захирал, "Ард Экс" XXK)
9. Ө. Үнэнбүрэн (ТУЗ-ийн дарга, "Комплекс Дижитал Экосистем" XXK)
10. О. Тэнүүн (Гүйцэтгэх захирал, "Оюуны Ундраа Групп" XXK)
11. Б. Эрхэмбаяр (Хөрөнгө оруулалт хариуцсан захирал, "Их бит" XXK
12. Н. Мөнхнасан (ТУЗ-ийн дарга, "Монполимет Групп" XXK
13. С. Хатансайхан (ТУЗ-ийн гишүүн, "Грийн групп" XXK)

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн:
1. Ч. Ганхуяг (Гүйцэтгэх захирал, "Ард Санхүүгийн Нэгдэл" XK)
2. Т. Тамир (Үйл ажиллагаа хариуцсан захирал, "ГрэйпСити Монгол XXK"
3. А. Баттамир (ТУЗ-ийн дарга "Дижитал Эксчэйнж Монголиа" XXK
4. Ч. Ганзориг (Гүйцэтгэх захирал, "Ард Экс" XXK)
5. Ө. Үнэнбүрэн (ТУЗ-ийн дарга, "Комплекс Дижитал Экосистем" XXK)
6. Б. Эрхэмбаяр (Хөрөнгө оруулалт хариуцсан захирал, "Их бит" XXK
7. М. Энх-Амгалан (Гүйцэтгэх захирал, "Эй Ай Дайверс Солюшнс" XXK
8. Н. Мөнхнасан (ТУЗ-ийн дарга, "Монполимет Групп" XXK) / О. Тэнүүн (Гүйцэтгэх захирал, "Оюуны Ундраа Групп" XXK)
9. А. Ундрал (Гүйцэтгэх захирал, "Тэнгэр ТВ" XXK) / С. Хатансайхан (ТУЗ-ийн гишүүн, "Грийн групп" XXK)

11.3 ТЕХНОЛОГИЙН БАГ

"Эй Ай Дайверс Солюшн" XXK-ийн технологийн багийн хамт олон нь MONT-д холбогдох бүх технологийн ажлыг гүйцэтгэсэн болно.



Технологийн баг

1. М. Энх-Амгалан (Гүйцэтгэх захирал, "Эй Ай Дайверс Солюшн" XXK)
2. Г. Мөнх-Од (Технологи хариуцсан захирал, "Эй Ай Дайверс Солюшн" XXK)
3. Д. Анхбаясгалан (Технологи хариуцсан захирал, "Ард Экс" XXK)©
4. Б. Ганболд (Бүтээгдэхүүн хариуцсан захирал, "ГрэйпСити Монгол" XXK
5. Ж. Мөнх-Эрдэнэ (Технологийн газрын захирал, "ГрэйпСити Монгол" XXK
6. П. Галбадрах (Технологийн газрын ахлах судалгаа хөгжүүлэлтийн инженер, "ГрэйпСити Монгол" XXK